



**Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2023 оны ээлжит 01 дүгээр хуралдааны  
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 01 дүгээр хуралдааныг 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр зохион байгуулав.

Монгол Улсын Ерөнхий Сайдын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн “Орон тооны бус гишүүн томилох тухай” 12 тоот захирамжаар Харилцаа холбооны тухай хуулийн 8.3, 8.4-т заасныг тус тус үндэслэн Алтай овогтой Лувсан-Очирыг Харилцаа холбооны зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр 6 жилийн хугацаагаар томилсон.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 01 дүгээр хуралдаанаар “Зөвшөөрлийн тухай” хуультай нийцүүлэн Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын баримт бичгүүдэд өөрчлөлт оруулах, хүчингүй болгох багц арга хэмжээний тухай (Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”; Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”; Радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”; “Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”; “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам” хүчингүй болгох тухай); “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн үйл үйл ажиллагаанд хийсэн шалгалт”-ын тайлан (Танилцуулга); Давамгай байдалтай үйлчилгээ эрхлэгч ДДэш ТВ ХХК-ийн үндсэн үйлчилгээний тариф батлах тухай; Давамгай байдалтай үйлчилгээ эрхлэгч Юнивишн ХХК-ийн үндсэн үйлчилгээний тариф батлах тухай (Хорооны 2022 оны 13 дугаар Тэмдэглэл); Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, сунгах, өөрчлөлт оруулах, сэргээх, хүчингүй болгох тухай; Орон нутгийн нэр бүхий телевизийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай) зэрэг асуудлыг хэлэлцэн нийт хорооны 13 тогтоолыг баталж, хорооны хуралдааны 2 тэмдэглэлээр хугацаатай удирдамж, чиглэлийн холбогдох бүтцийн нэгжид үүрэг болгон даалгав.

УИХ-аас Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээр хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн салбарын зохицуулалтын холбогдох баримт бичгүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж байна.

Харилцаа холбооны салбарын зохицуулалтын дүрэм журам, баримт бичиг, нөхцөл шаардлагыг Зөвшөөрлийн тухай болон холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэх зорилгоор ХХЗХ-ны даргын 2022 оны А/222 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллаж, хорооны 2023 оны ээлжит 01 дүгээр хуралдаанд Зөвшөөрлийн тухай хуулийг хэрэгжүүлж эхлэхтэй холбогдуулан боловсруулсан зохицуулалтын багц арга хэмжээний тухай асуудлыг авч хэлэлцэв. Үүнд: Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”; Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”; Радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”; “Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх тусгай

зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”; “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам” хүчингүй болгох тухай (Хорооны 2020 оны 64 тоот тогтоол) зэрэг болно. Тус хуралдаанаас Зөвшөөрлийн тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 1 дэх заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн “Нөхцөл, шаардлагад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 01 тоот тогтоолоор ХХЗХ-ны 2021 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д (ХЗДХЯ бүртгэл №5060) оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлав. Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.1 дэх заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дах заалтыг тус тус үндэслэн 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” 02 тоот тогтоолоор Харилцаа холбооны зохицуулах хорооны “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам”-ыг батлах тухай 2020 оны 64 дүгээр тогтоолыг (ХЗДХЯ бүртгэл №4904) Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн хүчингүй болгов. Зөвшөөрлийн тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 1 дэх заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн “Нөхцөл, шаардлагад өөрчлөлт оруулах тухай” 14 тоот тогтоолоор 2020 оны 88 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Радиоогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д (ХЗДХЯ бүртгэл №4970) оруулах өөрчлөлтийг; 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн “Нөхцөл, шаардлагад өөрчлөлт оруулах тухай” 15 тоот тогтоолоор 2021 оны 23 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д (ХЗДХЯ бүртгэл №5305) оруулах өөрчлөлтийг; 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн “Нөхцөл, шаардлагад өөрчлөлт оруулах тухай” 16 тоот тогтоолоор 2021 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д (ХЗДХЯ бүртгэл №5306) оруулах өөрчлөлтийг тус тус батлав. Эдгээр хуульд нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулж баталсан ХХЗХ-ны 2023 оны 5 тогтоолыг ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан нэмэлтээр бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын албан тоотор хүргүүлнэ.

Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 01 дүгээр хуралдаанд Даргын 2022 оны А/318 тоот тушаалаар байгуулагдаж, шалгалтыг 2022 оны 11-12 сард гүйцэтгэсэн ажлын хэсгийн “Улаанбаатар хотын ОСДҮЭ-ийн үйл ажиллагаанд хийсэн шалгалт”-ын ажлын хэсгийн тайлангийн танилцуулгыг сонсов. Ажлын хэсгийн шалгалтын тайлан, дүнгээр ОСДҮЭ-ийн үндсэн багцын сувгийн дараалалд хяналт хийхэд 4 ААН шаардлага хангаагүй; нийт 7 ААН гадаад сувгийн эзлэх хувь нь үндсэн багцын нийт сувгийн 30%-иас хэтрэлттэй 3 ОСДҮЭ-нь гадаад суваг ашигладаггүй; үндсэн багцад гадаадын аль нэш суваг нийт гадаадын сувгийн 30%-иас хэтрэхгүй байх заалтыг 1 ААН зөрчсөн; Үндсэн багц дахь гадаадын телевизийн сувгуудын эзэмшил зөвхөн нэг үлс биш байх гэсэн заалтыг бүх ОСДҮЭ-д хангаж байгаа үзүүлэлт гарсан байна. Хуралдаанаас ӨНЗГ-аас шалгалтад хамрагдсан нэр бүхий ТВ, ААН-ийн удирдлагад хугацаатай албан шаардлага, зөвлөмж хүргүүлж хэрэгжилтийг хангуулан ажиллах, хяналт тавьж нь зүйтэй гэж үзэв. Ажлын хэсгийн тайлан, дүгнэлтийг үйлчилгээ эрхлэгчид, хэрэглэгчид, олон нийтэд нээлттэй, ил тод болгох, хүртээл болгох зорилгоор байгууллагын цахим хуудаст байршуулав.

Зохицуулах хорооны 2022 оны ээлжит 12 дугаар хуралдаанаар “Давамгайл байдалтай үйлчилгээ эрхлэгч Юнивишн ХХК-ийн үндсэн үйлчилгээний үнэ тарифыг хянан батлах тухай” танилцуулга, тооцоолол судалгаа, саналын товчоо, тогтоолын төсөл, үнэ тариф

бүхий хавсралтын төслийг авч хэлэлцээд, хорооны хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Үнэ тарифын талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” хуралдааны 13 дугаар Тэмдэглэлээр хугацаатай үүрэг даалгавар, удирдамж чиглэл болгох болон холбогдох тодруулга, судалгаа авах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хорооны дараагийн ээлжит хуралдаанд дахин хэлэлцүүлэхийг холбогдох газарт даалгасан болно. ХХЗХ-ны 2023 оны ээлжит 01 дүгээр хуралдаанд Давамгай байдалтай үйлчилгээ эрхлэгч Юнивишн ХХК-ийн үйлчилгээний тариф батлах тухай, Хорооны 2022 оны 13 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн удирдамж, чиглэлийг хэрэгжүүлсэн тайлан, холбогдох судалгаа тооцоо, танилцуулга, тогтоолын төслийг тус тус дахин авч хэлэлцээд, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дах заалтыг үндэслэн 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 03 тоот “Үйлчилгээний тариф батлах тухай” тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэв. Энэхүү тогтоолоор Юнивишн ХХК-ийн үйлчилгээний тарифыг хавсралтад заасны дагуу тогтоож баталж, батлагдсан тарифын дагуу үйлчилгээний тарифыг тогтоож, хэрэглэгчдэд сурталчлах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэн ажиллахыг Юнивишн ХХК-д зөвшөөрөв. Уг тогтоол, тогтоож баталсан тарифыг тус компанийн удирдлагад албан ёсоор хүргүүлж, хамтран ажиллаж байна.

Зохицуулах хорооны 2023 оны 01 дүгээр хуралдаанаар Давамгай байдалтай үйлчилгээ эрхлэгч ДДэш ТВ ХХК-ийн үндсэн үйлчилгээний тариф батлах тухай, холбогдох судалгаа тооцоо, танилцуулга, тогтоолын төсөл, үйлчилгээний тариф тогтоох саналыг тус тус авч хэлэлцэв. Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дах заалтыг үндэслэн 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 04 тоот “Үйлчилгээний тариф батлах тухай” тогтоолыг баталж, Батлагдсан тарифын дагуу үйлчилгээний тарифыг тогтоож, хэрэглэгчдэд сурталчлах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэн ажиллахыг ДДэш ТВ ХХК-д зөвшөөрөв. Уг тогтоол, тогтоож баталсан тарифыг тус компанийн удирдлагад албан ёсоор хүргүүлж, хамтран ажиллаж байна.

ХХЗХ-ны 2023 оны ээлжит 01 дүгээр хуралдаанаар тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, сэргээх, нэмэлт өөрчлөлт оруулах, сунгах, шилжүүлэх, хүчингүй болгох, Орон нутгийн нэр бүхий телевизийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай) холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 9 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 9 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх заалт, 8.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн 9.3, 9.8, 9.12, 9.14, 9.15 дугаар заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийг тус тус үндэслэн 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 05 тоот тогтоолын хавсралтаар 11 хуулийн этгээдэд 15 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.1.5 дах заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалтыг тус тус үндэслэн 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 06 тоот тогтоолын хавсралтаар 7 хуулийн этгээдийн 7 тусгай зөвшөөрлийг сэргээсэн;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалтыг үндэслэн 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 07 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийн оноосон нэрд өөрчлөлт оруулсан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалтыг үндэслэн 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 08 тоот тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийн хамрах хүрээ, ашиглах давтамж, тоног төхөөрөмжийн тоо ширхэгт тус тус өөрчлөлт оруулсан;

- Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг үндэслэн 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 09 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйл, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалтыг тус тус үндэслэн 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 10 тоот тогтоолын хавсралтаар 22 хуулийн этгээдийн 22 тусгай зөвшөөрлийг сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт болон Сайхан монгол ЭИАК НҮТББ-ын хүсэлтийг тус тус үндэслэн 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 11 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.8 дах хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.3 дах заалт, Радио долгионы тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 12 тоот тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн 2 “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.2 дах хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 13 тоот тогтоолын хавсралтаар 7 хуулийн этгээдийн “Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх” 7 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон тус тус шийдвэрлэв.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо  
2023-02-03